

АЛСЫН ХАРАА

БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЭХ ЭМНЭЛЭГ БОЛОХ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг сонголтонд суурилсан, үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч нь байхад оршино.

ЗОРИЛГО

Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, хариуцлагатай, үр дүнтэй, чанар аулгүй байдлыг хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Ёс зүйтэй, хөрвөх чадвар бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн
- Ил тод, хариуцлагатай, мэргэжлийн нэгдмэл удирдлага
- Өндөр бүтээмжтэй техник технологи, материаллаг нөөц
- Тогтвортой, үр дүнтэй үр ашигтай үйл ажиллагаа
- Эрх тэгш нээлттэй шударга сайн түншлэлтэй байх

АЖИЛЛАХ ЗАРЧИМ

- Эрүүл мэндийн салбарын хэмжээний хандлагыг баримтлана.
- Нотолгоонд тулгуурласан техник, технологийг ашиглан, чанар аюулгүй байдлыг хангасан тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлэх
- Хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурласан байх
- Чадавхийг бэхжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх
- Эдийн засгийн зөв зохистой төлөвлөлт хийж, үр ашигтай ил тод хариуцлагатай байдлыг хангах

СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮРЭХ ҮР ДҮН:

- Хүний нөөцийн болон дэвшилтэт шинэ техник, технологийг хөгжил хангагдаж, өвчлөл, эндэгдэл буурна.
- Үр дүнтэй, үр ашигтай эрүүл мэндийн тогтолцоо бүрдэж, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний тогтвортой байдал хангагдана.
- Ядуу, эмзэг бүлгийн өрхийн эрүүл мэнд сайжирсанаар эрүүл мэнддээ зарцуулах зардал буурч, нийгмийн эрэлт хэрэгцээндээ түлхүү анхаарах боломжтой болно.
- Үйлчлүүлэгч төвтэй, хэрэглэгчдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ, байгууллагын тоо нэмэгдэнэ.

СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БА СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТРАТЕГИ:

СТРАТЕГИ 1. Хүн ам ялангуяа эх хүүхэд, ядуу эмзэг бүлгийн иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хамралт ашиглалтыг нэмэгдүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

- 1.1. Алслагдсан хөдөө орон нутгийн хүн амд түргэн тусламжийн үр дүнтэй чанартай үйлчилгээг яаралтай тусламж болон лавлагаат, өвчтөн шилжүүлэх тогтолцоотой уялдуулан цаг алдалгүй хүргэх
- 1.2. Үйлчлэх хүрээний хүн ам, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээний хамралт хүртээмжийг нэмэгдүүлж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
- 1.3. Үйлчлүүлэгчид ээлтэй хөтөч үйлчилгээний тогтолцоог бий болгож нэвтрүүлэх
- 1.4. ТҮНШБагцад тулгуурлан өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэлгүйгээр үйлчлүүлэгчид хүрч үйлчлэх тасралтгүй тогтвортой тогтолцоог бүрдүүлэх

СТРАТЕГИ 2: Тусламж үйлчилгээний нэмэлт багцын дагуу хоёрдогч болон гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагын чанартай, төрөлжсөн нарийн мэргэжлийн болон яаралтай тусламж үйлчилгээг бэхжүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

- 2.1. БОЭТ-ийн тусламж үйлчилгээний нэмэлт багцийг нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээтэй уялдуулан хэрэгжүүлж, үр дүнг нь тооцон ажиллах
- 2.2. Уламжлалт анагаах ухаан болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хамралт хүртээмжийг нэмэгдүүлэх

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Үйлчлэх хүрээний хүн ам тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, төлөвлөгөө батлагдан хэрэгжинэ.

- ТҮНШНБагцыг НЭМ болон анхан шатны тусламж үйлчилгээтэй уялдуулан хүргэснээр эх, хүүхэд, эмзэг бүлгийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний хамралт хүртээмж нэмэгдэнэ.
- Төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн уялдаа холбоо сайжирснаар нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдэнэ.
- Анхан шатны болон хоёрдогч шатлалын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт бүрэн хэрэгжиж, эрүүл мэндийн үзүүлэлт сайжирч иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээний түвшин нэмэгдэнэ.

ХОЁР. ЭМ ЗҮЙ БА ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТРАТЕГИ:

СТРАТЕГИ 3 : Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм биобэлдмэлээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

3.1. Эмнэлэгт хэрэглэгдэх зайлшгүй шаардлагатай эм, стационарын эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах

СТРАТЕГИ 4: Эм биобэлдмэл, цус цусан бүтээгдэхүүний чанарын баталгааг хангах тогтолцоо бий болгох

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

4.1. ЭМБ-ыг аюулгүй чанарын баталгаатай, донорын цус, цусан бүтээгдэхүүнээр жигд хүртээмжтэй хангах

СТРАТЕГИ 5: Эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

5.1. Байгууллагын хэмжээнд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг, бүртгэх мэдээлэх

СТРАТЕГИ 6: Эмнэлэг лабораторийн тоног төхөөрөмжийн байнгын нийлүүлэлт, засвар үйлчилгээг хангах тогтолцоо бий болгох замаар оношлогооны чадавхийг сайжруулах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

6.1. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтыг нэмэгдүүлж, шинэ техник технологийг нэвтрүүлэн үйл ажиллагааг чанаржуулах

СТРАТЕГИ 7: Байгууллагын бүтэц, барилгын засвар үйлчилгээ, тээвэр харилцаа холбооны үйл ажиллагааг тогтмолжуулах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

7.1. Эмнэлгийн барилга байгууламж, тээврийн хэрэгслийг шинэчлэх, засварлах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Эмнэлэг аюулгүй, чанарын баталгаатай, улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангагдана.
- Эмийн зохистой хэрэглээний талаарх иргэдийн мэдлэг сайжирч, оношлогооны чадавхи нэмэгдэнэ.
- Эмнэлэг, лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээ сайжирч, оношлогооны чадавхи нэмэгдэнэ.
- Эмнэлэг нь стандартын шаардлага хангасан барилга байгууламж, түргэн тусламжийн автомашин үе шаттайгаар шинэчлэгдсэн байна.

ГУРАВ. ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТ БА ХАРИЛЦАА

СТРАТЕГИ 8: Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн МСС-ны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

8.1. МСС-ны үйл ажиллагааны зохицуулалт, уялдааны өнөөгийн механизмыг нягтлан хянасны үндсэн дээр МСС-ны үйл ажиллагааг НЭМ-ийн талаар төрөөс баримтлах бодлого болон МСС-ны стратегитэй уялдуулах нэгдсэн механизм боловсруулж, баталгаажуулах

СТРАТЕГИ 9: Үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн тусламж үйлчилгээ бий болгох

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

9.1. Эмнэлгийн тусламж хайх, эрүүл мэндийг хамгаалах мэдлэг олгох боломж бүрдүүлэн, ЭМТҮ-гээ үзүүлэх ээлтэй, дэмжлэгт орчин бүрдүүлэх

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Эрүүл мэндийг дэмжих болон зан үйлийг өөрчлөх МСС-ны үйл ажиллагаа нь мэдээллийн бодит тогтолцоонд үндэслэн нэгтгэгдэн зохицуулагдана.
- Эрүүл орчин бүрдүүлэхэд чиглэсэн заавар журам хэрэгжиж эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, өрхийн тоо нэмэгдэнэ.
- Зан үйлийг өөрчлөх мэдээлэл сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо нэмэгдэнэ.
- НЭМ-н үйл ажиллагаатай холбоотой судалгаа, үнэлгээ хийгдсэн байна.

ДӨРӨВ. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

СТРАТЕГИ 10: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг салбарын хэмжээнд тасралтгүй сайжруулах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

10.1. Чанарын баталгааг хангасан үйлчилгээг нэвтрүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлэх

СТРАТЕГИ 11: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

11.1. Тусламж үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, чанарын болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгож мөрдүүлэх

СТРАТЕГИ 12: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг байгууллагын хэмжээнд тасралтгүй сайжруулах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

12.1. Чанарыг сайжруулахад хамтрагч талуудын оролцоог хангах

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар салбарын хэмжээнд тасралтгүй сайжирна.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, шалгуур үзүүлэлт оновчтой болсон байна.
- Чанарыг сайжруулахад хамтрагч талуудын оролцоо нэмэгдэнэ.

ТАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

СТРАТЕГИ 13: Хүний нөөцийн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох, мэргэжлийн ур чадвар, ёс зүйн харилцаа хандлагыг хэрэгжүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

13.1. Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого хэрэгжүүлж ажиллах

13.2. Мэргэжлийн өндөр ур чадвартай үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс зүйг дээдэлсэн эмнэлгийн мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх, чадавхижуулах

13.3. Байгууллагын хэмжээнд үйлчлүүлэгч төвтэй, үйлчлүүлэгчид ээлтэй тусламж үйлчилгээ бий болгох үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өргөдөл гомдлын ил, тод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх

СТРАТЕГИ 14: Байгууллагад мэргэжлийн боловсон хүчнийг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд үе шаттай хамруулах, эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлийн хэрэгжилт, эмнэлгийн ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

14.1. Төгсөлтийн дараах болон ажлын байрны тасралтгүй сургалтын тогтолцоог бий болгох, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн үйл ажиллагаанд хяналт тавьж хэрэгжүүлэх

СТРАТЕГИ 15: Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

15.1. Орон нутгийн дэмжлэг бүхий урамшууллын тогтолцоог нэвтрүүлж, эмнэлгийн ажилтан албан хаагчдын шилжилт хөдөлгөөнийг хянаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Мэргэшсэн чадварлаг, хөрвөх чадвартай мэргэжилтний тоо олширно.
- Харилцаа хандлага, ёс зүйг эрхэмлэгч хамт олон бий болсон байна.
- Үйлчилгээ үзүүлэгч эмч мэргэжилтэн, ажиллагсдын нийгмийн асуудал тодорхой түвшинд шийдвэрлэгдэж, урамшуулалын тогтолцоо бүрдэнэ.
- Байгууллагын үйл ажиллагаа, харилцаа хандлагатай холбоотой өргөдөл, гомдлын ил тод хяналтын тогтолцоо бүрдэн хуулийн хугацаанд шийдвэрлэгдэнэ.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ

СТРАТЕГИ 16: Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

16.1. Улсын төсвөөс санхүүжүүлж буй анхан, хоёрдогч, гуравдагч шатлалын тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулж, санхүүжилтийн зөв хуваарилалтын нөхцлийг бүрдүүлж ажиллах

16.2. Хөгжлийн албан ёсны туслалцааг хуваарилах, ашиглах, тайлагнах механизмыг оновчтой зохион байгуулах

СТРАТЕГИ 17: Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон холбогдох нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийг сайжруулах зорилгоор санхүүгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

17.1. Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон холбогдох нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийг сайжруулах зорилгоор санхүүгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх

СТРАТЕГИ 18: Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэлийг хэрэгжүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

18.1.Орон нутагт хуваарилагдсан ЭМДаатгалын санхүүжилтийг оновчтой хуваарилалтыг хэрэгжүүлэх

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Орон нутгийн төсөвт ЭМСалбарын зардлын эзлэх хувь тогтвортой өснө.
- Хөрөнгө оруулалтын ил тод байдал сайжирч, оновчтой урсгал бий болно.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний өртөг тооцогдож, санхүүгийн нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашиг сайжирна.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ БА САЛБАРЫН УДИРДЛАГА

СТРАТЕГИ 19: Байгууллагын хөгжлийн эрхэмлэх үнэт зүйлс, ажиллах зарчимд тулгуурлан аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжил, бүтэц зохион байгуулалтын удирдлагад шинэчлэл хийх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

- 19.1. Байгууллагын зохистой бүтэц бий болгох
- 19.2. Салбар дундын хамтын ажиллагааны өнөөгийн механизмыг боловсронгуй болгож үр дүнг сайжруулах
- 19.3. Удирдлагын хариуцлага, үр дүнг сайжруулахад байгууллагын соёлын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

СТРАТЕГИ 20: Удирдлагын шинэлэг арга барилыг нэвтрүүлэх, менежерүүдийг чадавхижуулах замаар эмнэлгийн тусламж үйлчилгээний ээлтэй байдлыг бүрдүүлэн байгууллагын хөгжлийг дэмжих

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

- 20.1. Эмнэлгийн удирдлагын төвлөрлийг сааруулах заавар журмыг хэрэгжүүлэх, удирдлагын чадавхийг бэхжүүлэх

СТРАТЕГИ 21: Эрүүл Мэндийн удирдлагын мэдээллийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлэх

СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ:

- 21.1. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, чанар агуулгыг сайжруулах
- 21.2. Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Эмнэлгийн менежментийн чадавхи сайжирч, хариуцлагатай ил тод, төвлөрөл саарсан тогтолцоонд шилжиж, үйл ажиллагаа жигдэрнэ.
- Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн нэгдмэл тогтолцооны үйл ажиллагаа чанаржина.